



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/285

Хэрлэн сум

Хан Хэнтий чуулгад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хан Хэнтий чуулгаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Учиртай гурван толгой” үндэсний дуурийг анх удаа тайзнаа бүтээл болгон тоглоход зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

05 05
A/285
Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
захирамжийн хавсралт

Зарцуулах хөрөнгийн төсөв тооцоо

№	Материалын нэр	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Лам дээл	300,000	2	600,000
2	Цэнхэр ард дээл (эмэгтэй)	250,000	5	1,500,000
3	Даавуу дээл (эрэгтэй)	180,000	5	900,000
Нийт				3,000,000